



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2018 оны 1 дүгээр  
сарын 31-ний өдөр


Дугаар 35

Улаанбаатар  
хот

Хөрөнгө гаргах тухай

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 8.3.7-д заасныг үндэслэн  
Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

Нийт нутгаар өвөлжилтийн байдал хүндрэх төлөвтэй байгаа зарим нутагт  
нөхцөл хүндэрсэнтэй холбогдуулан гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх,  
эрсдэлийг бууруулах, аймаг, орон нутгаас тавьсан хүсэлт, тулгамдсан асуудлыг  
шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор аймаг тус бүрд 110.0 (нэг зуун арван)  
сая төгрөг, нийт 2,310.0 (хоёр тэрбум гурван зуун арван) сая төгрөгийг Засгийн  
газрын нөөц сангаас гаргахыг Сангийн сайд Ч.Хүрэлбаатарт зөвшөөрсүгэй.



Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ

Сангийн сайд

Ч.ХҮРЭЛБААТАР

ТОГТ  
2018  
02/15

*Handwritten signature and date*  
02/15